



## **“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**


### **НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1. Энэхүү журмаар компаниас хувьцаа эзэмшигчдэд болон нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгсэл /нэвтрүүлэх, нийтлүүлэх мэдээллийн хэрэгсэл, давтамж/, хариуцах албан тушаалтан зэргийг тогтооно.
- 1.2. Компанийн хувьцааны үнэ ханшид нөлөөлөхүйц чухал мэдээллийг цаг тухайд нь нийтийн хүртээл болгох замаар компанийн үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгаж, хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, дотоод буюу нийтийн хүртээл болоогүй мэдээллийг шударга бусаар ашиглахаас сэргийлэх нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг байна. Харин энэ үйл ажиллагаанд компанийн ТУЗ нь Аудитын хороогоор дамжуулан хяналт тавина.
- 1.3. Компанийн гүйцэтгэх захирал нь хууль, зохицуулах байгууллагаас тогтоосон журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг цаг тухай бүр нийтэд хүргэх ажлыг биечлэн хариуцаж зохион байгуулах бөгөөд энэ мэдээллийн хувийг тухай бүр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 1.4. Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно.
  - 1.4.1. Тогтмол байх;
  - 1.4.2. Цаг хугацаандаа байх;
  - 1.4.3. Компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх;
  - 1.4.4. Үнэн зөв байх;
  - 1.4.5. Агуулгын хувьд бүрэн байх;
  - 1.4.6. Компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангах ;
  - 1.4.7. Өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаах, гоёчлон харуулах зорилго агуулаагүй.

### **ХОЁР. НИЙТЭД ХҮРГЭХ МЭДЭЭЛЭЛ**

- 2.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээр нь өөрчлөгдсөн тухай мэдээлэл.
- 2.2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл.
- 2.3. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/.
- 2.4. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл.
- 2.5. Компанийн томоохон даатгуулагчид, харилцагчдын тухай мэдээлэл /тухайн даатгуулагчийн даатгалын хураамжийн хэмжээ, зээлдүүлэгчээс авсан зээлийн хэмжээ болон тухайн харилцагчаас хүлээн авсан бараа материал зэргийн дүн болон тухайн этгээдтэй хийсэн ажил үйлчилгээний тухай хэлцлийн дүн нь компанийн нийт борлуулалтын 1-ээс дээш хувьтай тэнцүү бөгөөд тухайн харилцагчтай 2 болон түүнээс дээш жил тогтмол хамтран ажиллаж байгаа бол томоохон даатгуулагч, харилцагч гэж үзнэ/.



- 
- 2.6. Компани оролцогч нь болж буй компанийн нэгдэл болон түүний оролцогч компаниудын тухай мэдээлэл.
  - 2.7. Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаар болон халаасны хувьцаагаа худалдах тухай эрх бүхий байгууллага /ТУЗ хуулиар тогтоосон нөхцөлд ХЭХ/ шийдвэрлэсэн тухай мэдээлэл.
  - 2.8. Компанийн нэр, ерөнхий захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэл.
  - 2.9. Компани шинээр салбар, төлөөлөгчийн газартай болсон, татан буулгасан тухай мэдээлэл.
  - 2.10. Компанийн үйл ажиллагааны чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл.
  - 2.11. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн мэдээлэл.
  - 2.12. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл.
  - 2.13. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/-г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан тухай мэдээлэл.
  - 2.14. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан тухай мэдээлэл.
  - 2.15. Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ эсвэл хуульд заасан тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал баталсан тухай мэдээлэл.
  - 2.16. Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10-ээс дээш хувьтай тэнцэх үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл.
  - 2.17. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн тухай мэдээлэл.
  - 2.18. Компанийг нэтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх зэргээр хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан тухай мэдээлэл.
  - 2.19. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан тухай мэдээлэл.
  - 2.20. Компанийн санхүүгийн тайлан, төрийн зохицуулалтын байгууллагаас тогтоосон нэмэлт, тайлбар тодруулга, хөндлөнгийн аудитын дүгнэлтийн хамт.
  - 2.21. Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайлан.
  - 2.22. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа бүтээгдэхүүнийг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай.
  - 2.23. Компанийн үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл.
  - 2.24. Компанийн үйл ажиллагаанд болон хувьцааны үнэ ханшид нөлөөлж болно гэж ТУЗ үзсэн бусад асуудал.
  - 2.25. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс нийтийн хүртээл болгохоор тогтоосон бусад мэдээлэл.

### **ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАНД ЗААВАЛ ТУСГААГДАХ МЭДЭЭЛЭЛ**

- 3.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:
  - 3.1.1. Компанийн үйл ажиллагааны стратеги, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;
  - 3.1.2. Компани даатгалын салбартаа эзлэх байр суурь;





- 3.1.3. Даатгалын зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл;
  - 3.1.4. Тайлан хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 3.1.5. Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан;
  - 3.1.6. Нийгмийн хариуцлагын тайлан.
- 3.2. Удирдлагын талаарх мэдээлэл:
- 3.2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
  - 3.2.2. ТУЗ, гүйцэтгэх удирдлага, болон бусад ЭБАТ-ны талаарх мэдээлэл;
  - 3.2.3. ТУЗ, гүйцэтгэх удирдлага, болон бусад ЭБАТ-ны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;
  - 3.2.4. ТУЗ болон түүний дэргэдэх Хороодын үйл ажиллагааны тайлан;
  - 3.2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
  - 3.2.6. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан.
- 3.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:
- 3.3.1. Компанийн жил хагас жилийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
  - 3.3.2. Аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлтийн хамт;
  - 3.3.3. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;
  - 3.3.4. Тухайн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн харьцаа;
  - 3.3.5. Жилийн туршид авсан зээлийн хэмжээ эргэн төлөлт болон барьцаа баталгаа, гаргасан талаарх мэдээлэл.
- 3.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:
- 3.4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
  - 3.4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч /бенефициар эзэмшигч/ этгээдийн талаарх мэдээлэл;
  - 3.4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
  - 3.4.4. Компанийн ЭБАТ болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бусад компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл.
- 3.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:
- 3.5.1. Компанийн ногдол ашгийн бодлого;
  - 3.5.2. Тухайн жил хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хуваарилаагүй бол түүний үндэслэл, шалтгааны талаарх мэдээлэл.
- 3.6. Бусад шаардлагатай мэдээлэл:
- 3.6.1. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл;
  - 3.6.2. Компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;
  - 3.6.3. Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл.



**ДӨРӨВ. ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ӨМНӨ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ЗААВАЛ ТОЛИЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ**



- 4.1. Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан /энэ журмын Гуравдугаар хэсэгт заасан мэдээллийг агуулсан/.
- 4.2. Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитын байгууллагын дүгнэлтийн хамт.
- 4.3. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл.
- 4.4. Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга.
- 4.5. Тайлангийн жил хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудиторын дүгнэлт.
- 4.6. Компанийн болон хяналтын багц хувьцаа эзэмшигчдийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл /хэрэв тэдгээр нь компанийн хувьцааг эзэмшдэг бол/.
- 4.7. Компанийн ТУЗ-ийн гишүүд гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал.
- 4.8. Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт.
- 4.9. Компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг.
- 4.10. Нэмж хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх журам.
- 4.11. Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо.
- 4.12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан байна.

**ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ**

- 5.1. Хууль, зохицуулах байгууллагын журам, компанийн дүрэм болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр цаг тухайд нь саадгүй гаргаж өгнө.
- 5.2. Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо, Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржийн дүрэм журмаар тогтоосон болон энэхүү журмын хоёрдугаар хэсэгт заасан мэдээллийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр танилцуулна.
- 5.3. Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад бичиг баримттай танилцах, төлбөртэй хуулбарлан авах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна.
- 5.4. Мэдээлэл хүсэж байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтдээ өөрийн болон эцэг /эх/ -ийн нэр, хаяг /шуудангийн болон электрон/, холбоо барих утас, эзэмшиж байгаа



- хувьцааны тоо, төрөл, авахыг хүсэж байгаа мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр /биечлэн, бичгээр, электрон шуудангаар/ зэргийг заасан байна.
- 5.5. Уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор /мэдээлэл ач холбогдлоо алдахаар бол боломжит богино хугацаанд/ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит хэлбэрээр хүргүүлнэ.
- 5.6. Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компанийн дотоод бичиг баримтаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компанийн бизнесийн нууцад хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлнэ.



### **ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД ТУХАЙ БҮР ХҮРГЭХ МЭДЭЭЛЭЛ**

- 6.1. 2019 оны 1 дүгээр сарын 09-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц журам”-ын дагуу дараах мэдээллийг тухай бүр журамд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Үүнд:
- 6.1.1. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 4.2-т заасны дагуу уг журмын нэгдүгээр хавсралт “СЗХ04144” маягт болон хоёрдугаар хавсралт “СЗХ04145” маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ;
- 6.1.2. “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”-ын 5.3-т заасны дагуу жолоочийн даатгалын гэрээний, хохирогчид олгосон нөхөн төлбөрийн болон гэрээнд орсон өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр мэдээллийн санд хүргүүлнэ;
- 6.1.3. Компанийн үйл ажиллагаанд Хорооноос газар дээр шалгалт хийж хугацаатай үүрэг даалгавар өгсөн бол тухайн заасан хугацаанд хэрэгжилтийн тайланг хороонд хүргүүлж байна.

### **ДОЛОО. ХАРИУЦЛАГА**

- 7.1. Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн бирж, компанийн дүрэм болон энэхүү журмаар тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгох, эрх бүхий зохицуулах байгууллагад хүргүүлэх, хувьцаа эзэмшигчийг мэдээллээр цаг хугацаанд нь бүрэн хангах үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтны талаар Аудитын хороо, ТУЗ-ийн хуралдаанд танилцуулна.
- 7.2. Аль нэг албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас Компанийн тухай болон бусад холбогдох хуулийн дагуу компанид захиргааны хариуцлага хүлээлгэсэн бол холбогдох буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 7.3. Эрх бүхий албан тушаалтан нь мэдээллийг нийтийн хүртээл болгох, хувьцаа эзэмшигчид эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл удаа дараа хугацаа хожимдуулсан, хуурамч бодитой бус мэдээлэл өгсөн бол энэ нь албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болно.